

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох зохицуулалтад Байнгын хороо нь эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой чиглэлээр дэд хороо байгуулж ажиллуулах эрхтэй бөгөөд дэд хороо нь тухайн салбарын асуудлыг нарийвчлан судалж, урьдчилсан санал, дүгнэлт боловсруулах, хяналт шалгалтын ажлыг мэргэшүүлэн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй болохыг тусгасан байна.

Эдийн засгийн байнгын хороо нь макро эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн бодлогыг хэлэлцдэг өргөн хүрээний чиг үүрэгтэй тул эрчим хүчний салбарын асуудал нь тус хорооны хэлэлцэх асуудлын чухал хэсэг болж байна.

Эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, аж үйлдвэржилт, уул уурхай, бүсчилсэн хөгжил, экспортын өсөлт, иргэдийн амьдралын чанарт эрчим хүчний салбар стратегийн суурь ач холбогдолтой болсон хэдий ч тус салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн уялдаа, бодлогын хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

Улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, эрчим хүчний хараат байдлыг бууруулах, бүс нутгийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зэрэг зорилтууд тусгагдсан боловч эдгээр бодлого, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, нэгдсэн хяналт, парламентын тогтолцоот дэмжлэг дутагдаж байна.

Мөн эрчим хүчний салбарын хууль тогтоомж, бодлого, хөрөнгө оруулалт, хэрэгжилтэд байнгын хяналт тавих, Засгийн газар болон Эрчим хүчний яамны үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих, шахаж ажиллуулах, төр-хувийн хэвшил-иргэдийн оролцоог уялдуулах шаардлага үүсээд байна.

Иймд эрчим хүчний салбарын бодлогын хэрэгжилтэд парламентын хяналтыг сайжруулах, эрчим хүчний томоохон төслүүдийн хэрэгжилт эрчимжүүлэх, эрчим хүчний реформ, хөрөнгө оруулалтын асуудлыг тогтмол хэлэлцүүлэх, эрчим хүчний хараат байдлыг бууруулах бодлогын хэрэгжилтэд ахиц гаргах, улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт туссан зорилтуудын хэрэгжилтийг хангах парламентын институцийн механизм бүрдэх ач холбогдолтой Монгол Улсын Их Хурлын бүтцэд “Эрчим хүчний хөгжлийн дэд хороо” байгуулах хуулийн төсөл боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлын нэг нь эрчим хүчний салбарын хүчин чадлын дутагдал, төвлөрсөн бүтэц, импортын хамаарал, хөрөнгө оруулалтын саатал, бодлогын хэрэгжилтийн сул байдал болоод байна.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний хэрэглээ тогтмол өсөх, үйлдвэрлэл, уул уурхай, боловсруулах үйлдвэрүүдийн эрчим хүчний хэрэгцээ нэмэгдэх, нийслэл болон орон нутгийн эрчим хүчний ачаалал хэтрэх, импортын эрчим хүчний хараат байдал нэмэгдэх, шинэ эх үүсвэр, дэд бүтцийн төслүүд удаашрах, сэргээгдэх эрчим хүчний зохицуулалт, хөрөнгө оруулалтын орчин хангалтгүй байх зэрэг асуудлууд хуримтлагдсаар байна.

Эрчим хүчний салбар нь зөвхөн нэг салбарын асуудал бус Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, аж үйлдвэржилт, бүсчилсэн хөгжил, хөрөнгө оруулалтын орчин, иргэдийн амьдралын чанарт шууд нөлөөлөх стратегийн ач холбогдолтой салбар юм. Гэвч салбарын бодлого, хууль тогтоомж, томоохон төслүүдийн хэрэгжилтэд парламентын түвшний дагнасан бүтэц, тогтмол хяналт, бодлогын уялдаа хангалтгүй байна.

Монгол Улсын Их Хурал нь ард түмнийг төлөөлөх дээд байгууллагын хувьд улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон эрчим хүчний салбарт бодлогын нэгдсэн удирдлага, хяналт, хэрэгжилтийн механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд:

- эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулах;
- сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх;
- эрчим хүчний экспортлогч орон болох;
- эрчим хүчний хараат байдлыг бууруулах;
- бүс нутгийн эрчим хүчний интеграцид нэгдэх;
- тариф, менежментийн шинэчлэл хийх зэрэг олон зорилт тусгагдсан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Иймд эдгээр бодлого, зорилтын хэрэгжилтийг парламентын түвшинд тогтмол хэлэлцэх, хяналт тавих, салбар хоорондын уялдааг хангах, Засгийн газар болон Эрчим хүчний яамны үйл ажиллагаанд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын бүтцэд “Эрчим хүчний хөгжлийн дэд хороо” байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэв.

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын Их Хурлын бүтцэд “Эрчим хүчний хөгжлийн дэд хороо” байгуулж эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого, хууль

тогтоомжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалт, томоохон төсөл, хөтөлбөрийн явц, эрчим хүчний аюулгүй байдал, сэргээгдэх эрчим хүчний хөгжил, эрчим хүчний хараат байдлыг бууруулах асуудлыг тогтмол хэлэлцэх, парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оршино.

Хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулж, Байнгын хорооны харьяанд “Эрчим хүчний хөгжлийн дэд хороо” байгуулахаар тусгав.

Эрчим хүчний хөгжлийн дэд хороо байгуулагдсанаар дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

- эрчим хүчний салбарын бодлогын хэрэгжилтэд парламентын хяналт сайжрах;
- томоохон төсөл, хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийн хэрэгжилт эрчимжих;
- эрчим хүчний салбарын реформын асуудал тогтмол хэлэлцэгдэх;
- төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжрах;
- эрчим хүчний аюулгүй байдал, хараат бус байдлыг хангах бодлогын хэрэгжилтэд ахиц гарах;
- эдийн засгийн өсөлт, аж үйлдвэржилтийн суурь нөхцөл бэхжих;
- иргэд, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэх ач холбогдолтой.

---oOo---